



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

ХААИС-ийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/138/НА-СА-ТШЗ

---

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

Аудитор: **З.Мөнгөнцэцэг**

Утас: **9937-2208**

Цахим хаяг: [Munguntsetseg@audit.gov.mn](mailto:Munguntsetseg@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48210 Дархан-Уул аймэг  
Дархан сум, 14 урд баг  
Утас: 7007-3060, Факс: 0701 7007-3060  
E-mail: darhantay@sa.gov.mn

2021 оны 12 сарын 25  
№ 42

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**ХААИС-ИЙН ХАРЬЯА УРГАМАЛ ГАЗАР  
ТАРИАЛАНГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ Н.БАЯРСҮХ ТАНАА**



**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ХААИС-ийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ХААИС-ийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа болсон материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа бич юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР**



000070135

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	842.7	1,028.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,611.7	21,294.3
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>22,454.4</b>	<b>22,322.4</b>
	Нийт өр төлбөрийн дүн	121.5	134.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	22,332.9	22,187.6
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>22,454.4</b>	<b>22,322.4</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,967.5	3,157.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	4,006.3	3,524.4
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(38.8)</b>	<b>(367.2)</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	123.2	221.8
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>84.3</b>	<b>(145.3)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		
	Тайлант оны үр дүн	84.3	145.3
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>84.3</b>	<b>145.3</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,429.7	2,857.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,389.3	2,688.4
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>40.5</b>	<b>168.7</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(40.5)</b>	<b>(168.7)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,716.9</b>	<b>1,716.7</b>
	Урсгал зардал	1,716.9	1,716.7
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,716.9</b>	<b>1,716.7</b>
	Улсын төсвөөс санхүүжих	1,716.9	1,716.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

ХААИС-ийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэн нь эх орны таримал, сортуудын нэр төрлийг олшруулах, тэдгээрийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх, тариалангийн технологийг улам бүр экологийн чиг баримжаатай боловсронгуй болгох зэрэг Монгол орны газар тариалангийн салбарын өмнө тулгамдсан асуудлуудыг шинжлэх ухааны үндэстэй шийдвэрлэж, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар экспортын чиг хандлагатай, мэдлэгт суурилсан тариалангийн салбарын хөгжил, дэвшилд бодитой хувь нэмэр оруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

### **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Дөрөв. Аудитын гол асуудал**

ХААИС-ийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Тус байгууллага нь тайлант онд төсвийн гүйцэтгэлийн 7 дугаар сарын мэдээ хоцроож, 11 дүгээр сарын мэдээг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 28,300.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг хугацаа хоцроож, 121,323.0 мянган төгрөгийн 15 зарлагын гүйлгээ, 172,179.8 мянган төгрөгийн 9 орлогын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 133,893.7 мянган төгрөгийн 17 мэдээлэл, эхний хагас жилийн санхүүгийн тайланг тус тус мэдээлээгүй байна.

### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

### **Долоо. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 463,412.0 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илрүүлснээс 373.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 455,696.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, 7,341.6 мянган төгрөгийн алдаа зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

#### ***Залруулсан алдаа***

Залруулсан алдаа байхгүй.

#### ***Төлбөрийн акт***

Тус байгууллагын сахиул Ч.Амартүвшингийн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 373.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон.

### **Албан шаардлага**

Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй, төсвийн гүйцэтгэлийн 7 дугаар сарын мэдээ хоцроож, 11 дүгээр сарын мэдээг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 28,300.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ хугацаа хоцроож, 121,323.0 мянган төгрөгийн 15 зарлагын гүйлгээ, 172,179.8 мянган төгрөгийн 9 орлогын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 133,893.7 мянган төгрөгийн 17 мэдээлэл, эхний хагас жилийн санхүүгийн тайланг тус тус мэдээлээгүйд албан шаардлага хүргүүлээ.

### **Зөвлөмж**

Тус байгууллага нь 5,915.4 мянган төгрөгийн авлага, 1,426.2 мянган төгрөгийн өглөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байгаад зөвлөмж өгсөн.

### **7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

## 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	3	463.4			1	0.4	1	455.7	1	7.3
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	<b>НИЙТ</b>	<b>3</b>	<b>463.4</b>			<b>1</b>	<b>0.4</b>	<b>1</b>	<b>455.7</b>	<b>1</b>	<b>7.3</b>